

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 07 дугаар сарын 07-ны өдөр

№ 25/36


Улаанбаатар хот

**Өрийн хэрэгсэл нийтэд санал болгон
гаргах тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсэг, 41 дүгээр зүйл, 42 дугаар зүйлийн 42.1 дэх хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.5 дахь заалт, 80 дугаар зүйл, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2 дахь заалт, 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг, 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг, 16 дугаар зүйл, Санхүүгийн Зохицуулах Хорооны 2021 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн 226 дугаар тогтоолоор батлагдсан “Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам”, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.2, 9.6.4 дэх заалт, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн 2025 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн 25/22 тоот тогтоолоор батлагдсан “Компанийн 2025 оны эх үүсвэрийн төлөвлөгөө”, Компанийн ТУЗ-ийн 2025 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн эцнээ санал хураалтын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Компанийн үндсэн үйл ажиллагааг санхүүжүүлэх зорилгоор 15,000,000,000 (арван таван тэрбум) төгрөгийн нийт дүн бүхий хөтөлбөртэй өрийн хэрэгсэл (цаашид “Өрийн хэрэгсэл”)-ийг нийтэд санал болгон гаргахаар шийдвэрлэсүгэй.
2. Нийтэд санал болгон гаргах өрийн хэрэгслийн нөхцөлийг энэхүү тогтоолын Хавсралтаар баталсугай.
3. Андеррайтерын үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн байгууллагаар “Мандал Капитал Маркетс ҮЦК” ХХК-ийг, Хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлэгчээр “Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс” ХХН-ийг, Аудитын үйлчилгээ үзүүлэгчээр “Шонхор Үнэлгээ Аудит” ХХК-ийг тус тус сонгосугай.
4. “Мандал Капитал Маркетс ҮЦК” ХХК-тай “Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх гэрээ” байгуулах болон үнэт цаасны зах зээлд оролцогч бусад эрх бүхий этгээдтэй хэлцэл хийх, гэрээ байгуулахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д олгосугай.
5. Өрийн хэрэгслийг нийтэд санал болгож, санхүүжилт татан төвлөрүүлэх ажлыг зохион байгуулж, холбогдох баримт бичиг, бусад шаардлагатай гэрээ, хэлцэлд Компанийг төлөөлөн гарын үсэг зурж баталгаажуулах эрхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д олгосугай.
6. Өрийн хэрэгсэл гарган санхүүжилт татан төвлөрүүлэх ажилтай холбогдон гарах аливаа төлбөр, шимтгэл, хураамж, бусад зардлыг холбогдох гэрээ, хууль тогтоомжид заагдсан хугацааны дотор тухай бүр төлөх, Өрийн хэрэгслийн үндсэн болон хүүгийн төлбөрийг хугацаанд нь төлж барагдуулан ажиллахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д даалгасугай.
7. Өрийн хэрэгсэл нийтэд гаргахтай холбоотой ажлын үйл явц, үр дүн болон энэхүү тогтоолын хэрэгжилтийн талаар Компанийн ТУЗ-д тухай бүр танилцуулахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д үүрэг болгосугай.





НИЙТЭД САНАЛ БОЛГОХ ҮНЭТ ЦААСНЫ НӨХЦӨЛ

1	Үнэт цаасны нэр	Лэнд жендер бонд
2	Үнэт цаасны төрөл	Энгийн тогтмол хүүтэй хөтөлбөртэй өрийн хэрэгсэл (бонд)
3	Арилжаа эрхлэх байгууллага	Монголын хөрөнгийн бирж
4	Олон нийтэд санал болгох нийт дүн	15,000,000,000 (арван таван тэрбум) төгрөг
5	Бондын нэрлэсэн үнэ	100,000 (нэг зуун мянга) төгрөг
6	Тоо ширхэг	150,000 (нэг зуун тавин мянга) ширхэг
7	Хүүгийн хувь хэмжээ (жилийн буюу 365 хоног)	19% (арван есөн хувь)
8	Хугацаа	24 (хорин дөрөв) сар
9	Хүү төлөгдөх давтамж	Улирал тутам буюу 8 (найм) удаа
10	Үндсэн төлбөр төлөгдөх хугацаа	Хугацааны эцэст
11	Татан төвлөрүүлсэн хөрөнгийг зарцуулах зориулалт	Компанийн “Тогтвортой байдлын бодлого”-ын дагуу Эмэгтэйчүүд рүү чиглэсэн санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлж, үйл ажиллагааг нь санхүүжүүлэх
12	Санхүүжих чадавхын зэрэглэл	“BBB” буюу “Дунд зэргийн эрсдэлтэй, хөрөнгө оруулалтын дундаж зэрэглэл”
13	Үндсэн андеррайтер	“Мандал Капитал Маркетс ҮЦК” ХХК
14	Үнэт цаасны бүртгэл, хадгаламжийн байгууллага	“Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК
15	Нийтэд санал болгох хугацаа	- Транч 1 - 2025 оны 9 сард 12,000,000,000 (арван хоёр тэрбум) төгрөг буюу нэг бүр нь 100,000 (нэг зуун мянга) төгрөгийн нэрлэсэн үнэтэй 120,000 (нэг зуун хорин мянга) ширхэг өрийн хэрэгсэл - Транч 2 – 2025 оны 12 сар 3,000,000,000 (гурван тэрбум) төгрөг буюу нэг бүр нь 100,000 (нэг зуун мянга) төгрөгийн нэрлэсэн үнэтэй 30,000 (гучин мянга) ширхэг өрийн хэрэгсэл (Зохицуулах байгууллагын зөвшөөрөл болон компанийн тухайн үеийн санхүүгийн үзүүлэлтээс хамааран транчийн хугацаа, үнийн дүн өөрчлөгдөх боломжтой)